



I-X/2021

Тархаасан: 2021 оны 12 дугаар сарын 13




## Нийтийн хоолны салбарын орлого өмнөх сараас 6.1 хувиар өсжээ

Нийтийн хоолны салбарын орлого 2021 оны эхний 10 сард 495.2 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 30.1 (5.7%) тэрбум төгрөгөөр буурчээ. Үүнд рестораны орлого 29.2 (9.5%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн байна. Харин захиалгат хоолны хүргэлтийн үйлчилгээний орлого өмнөх оны мөн үеэс 5.2 (5.3%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нийтийн хоолны салбарын орлого 2021 оны 9 дүгээр сард 69.7 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 1.4 (2.0%) тэрбум төгрөг, 10 дугаар сард 74.0 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 4.2 (6.1%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

ЗУРАГ 1. НИЙТИЙН ХООЛНЫ САЛБАРЫН ОРЛОГО, төрлөөр, тэрбум төгрөг, жил бүрийн эхний 10 сард



Захиалгат хоолны хүргэлтийн үйлчилгээний орлогын эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 2.2 нэгж хувь, гуанзных 0.3 нэгж хувь, кафеных 0.1 нэгж хувиар өсөж, харин рестораны орлогын эзлэх хувь 2.4 нэгж хувь, баарных 0.2 нэгж хувиар тус тус буурсан байна.


## Зочид буудлын салбарын орлого өмнөх сараас 5.9 хувиар өсжээ

Зочид буудлын салбарын орлого 2021 оны эхний 10 сард 160.8 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 9.7 (6.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Үүнд 3, түүнээс дээш одтой буудлын орлого 6.7 (7.0%) тэрбум төгрөг, зэрэглэлгүй зочид буудал болон амралтын газрын орлого 3.3 (6.3%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Зочид буудлын салбарын орлого 2021 оны 9 дүгээр сард 23.0 тэрбум төгрөг болж өмнөх сараас 594.3 (2.5%) сая төгрөгөөр буурч, харин 10 дугаар сард 29.0 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 5.9 (25.8%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Үүнд 3, түүнээс дээш одтой буудлын орлого 5.4 (36.6%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Зочид буудлын салбарын 2021 оны эхний 10 сарын орлогын 63.5 хувийг 3, түүнээс дээш одтой зочид буудал, 34.6 хувийг зэрэглэлгүй зочид буудал, амралтын газар, 1.9 хувийг 2 одтой зочид буудлын орлого эзэлж байна.

ЗУРАГ 2. ЗОЧИД БУУДЛЫН САЛБАРЫН ОРЛОГО, зэрэглэлээр, тэрбум төгрөгөөр, жил бүрийн эхний 10 сард



### Ойлголт, тодорхойлолт

Нийтийн хоолны салбарт ресторан, кафе, баар, гуанз, захиалгат хоол хүргэх, үйлчлэх үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдийг хамруулна.

Зочид буудлын үйл ажиллагаанд зочид буудал, амралтын газар, хүүхдийн зуслан, түр хоноглох байруудын үйл ажиллагаа хамрагдана.



### Эх үүсвэр:

Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч хуулийн этгээдийн мэдээллийн сан

### Ангилал, код:

Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал

### Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>  
<http://www.1212.mn/>

### Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 1 дүгээр сарын 17

Эдийн засгийн статистикийн газрын  
дарга А.Дэмбэрэл  
Утас : (976-51)-329278

Эдийн засгийн статистикийн газрын Мөнгө,  
санхүү, үйлчилгээний статистикийн хэлтсийн  
статистикч Ч.Мөнхтуул  
Утас : (976-51)-264797



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212